



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 1 нэрийн, нийт 3,277,692.00 (гурван сая хоёр зуун далан долоон мянга зургаан зуун ерэн хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,638,846.00 (нэг сая зургаан зуун гучин найман мянга найман зуун дөчин зургаан) төгрөгөөр шинэчлэн тогтоож, 10 нэрийн, нийт 286,817,928.00 (хоёр зуун наян зургаан сая найман зуун арван долоон мянга есөн зуун хорин найм) төгрөгийн балансын үнэ, 61,094,086.90 (жаран нэгэн сая ерэн дөрвөн мянга наян зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ
132001849
17-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
362 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООЖ, ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭГТЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жих нэгж	Ашиглал тад орсон огноо	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Шилжүүлэн авах хуулийн этгээлийн нэр
										Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Зөөврийн компьютер /Dell Vostro BTX-3580/	1,638,846.00	ш	19.12.18	1	1,638,846.00	1,638,846.00	0	2	1	819,423.00	819,423.00	Гадаад харилцааны яам
2	Зөөврийн компьютер /Dell Vostro BTX-3580/	1,638,846.00	ш	19.12.18	1	1,638,846.00	1,638,846.00	0	2	1	819,423.00	819,423.00	
3	Зургийн аппарат /Canon/	1,139,648.00	ш	21.10.18	1	1,139,648.00	641,052.00	498,596.00					
4	Хурууны хээ уншигч /CrossMatc/	2,393,750.00	ш	21.10.18	1	2,393,750.00	1,077,187.50	1,316,562.50					
5	Зургийн аппарат /Canon/	1,139,648.00	ш	21.10.18	1	1,139,648.00	641,052.00	498,596.00					
6	Хурууны хээ уншигч /CrossMatc/	2,393,750.00	ш	21.10.18	1	2,393,750.00	1,196,875.00	1,196,875.00					
7	Зөөврийн компьютер /Dell 3540 i5/	3,660,580.00	ш	23.10.23	36	131,780,880.00	19,218,045.00	112,562,835.00					Дотоод хэргийн их сургууль
8	Принтер /Epson TM-U220/ Дүн	1,241,460.00	ш	23.10.23	36	44,692,560.00	6,517,665.00	38,174,895.00					
1	Зөөврийн компьютер /Dell Vostro BTX-3580/	400,000.00	ш	23.12.14	78 200	186,817,928.00 80,000,000.00	32,569,568.50 22,819,614.72	154,248,359.50 57,180,385.28					
	Дүн				200	80,000,000.00	22,819,614.72	57,180,385.28					Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
1	Зөөврийн компьютер /Dell Vostro BTX-3580/	400,000.00	ш	23.12.14	50	20,000,000.00	5,704,903.68	14,295,096.32					
	Дүн				50	20,000,000.00	5,704,903.68	14,295,096.32					
	НИЙТ ДҮН					286,817,928.00	61,094,086.90	225,723,841.10				1,638,846.00	